



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид засаж, сэлбэн ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон 315,362,448.32 (гурван зуун арван таван сая гурван зуун жаран хоёр мянга дөрвөн зуун дөчин найман төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 190,107,385.13 (нэг зуун ерэн сая нэг зуун долоон мянга гурван зуун наян таван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн элэгдэл бүхий илчит тэргийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар тогтоосугай.

2. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг үйлдвэрийн газрын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 08 дугаар сарын 24 ны өдрийн  
76 дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛПРОСЦЕВМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д      | Хөрөнгийн нэр             | Үйлдвэрлэгдсэн/<br>Ашиглалтад<br>орсон он | Балансын үнэ<br>(төгрөг)                                                                                                         | Хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                                                                         | Үлдэх өртөг<br>(төгрөг)                                                                                       | Сэргээн босголтын<br>өртөг (төгрөг)                                                                       | Худалдах доод<br>үнэ (төгрөг) | Дэнчингийн<br>хэмжээ (төгрөг) |
|----------|---------------------------|-------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|-------------------------------|
| 1        | Илчит тэрэг,<br>ТЭМ2-1093 | 1972/1972                                 | 315,362,448.32                                                                                                                   | 190,107,385.13                                                                                            | 125,255,063.19                                                                                                | 181,602,604.32                                                                                            | 200,000,000.00                | 30,000,000.00                 |
| Нийт дүн |                           |                                           | (гурван зуун<br>арван таван сая<br>гурван зуун<br>жаран хоёр<br>мянга дөрвөн<br>зуун дөчин<br>найман төгрөг<br>гучин хоёр мөнгө) | (нэг зуун ерэн сая<br>нэг зуун долоон<br>мянга гурван зуун<br>наян таван төгрөг<br>арван гурван<br>мөнгө) | (нэг зуун хорин<br>таван сая хоёр<br>зуун тавин таван<br>мянга жаран<br>гурван төгрөг<br>арван есөн<br>мөнгө) | (Нэг зуун наян нэгэн<br>сая зургаан зуун хоёр<br>мянга зургаан зуун<br>дөрвөн төгрөг гучин<br>хоёр мөнгө) | (хоёр зуун сая                | (гучин сая)                   |